

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/197/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМАГ АРХУСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага.....	22
5.3 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМНДШ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 9/59
танай _____-ны № _____-г

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
А.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд өөрийн орлогыг давуулан биелүүлсэн ба үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд орхигдуулсан асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Зураг төсөвгүй ахуй үйлчилгээний засварын ажил 8,000.0 мянган төгрөгийг гэрээ байгуулан төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,453,268.4	88,395,078.7
33	АВЛАГА	0.0	5,944,721.2
335	Бусад авлага	0.0	5,944,721.2
3351	Байгууллагаас авах авлага	0.0	5,944,721.2
35	БАРАА МАТЕРИАЛ	68,453,268.4	82,450,357.4
351	Түүхий эд материал	92,066.4	92,066.4
35110	Тусгай зориулалттай материал	92,066.4	92,066.4
354	Хангамжийн материал	60,561,202.0	63,358,291.0
35410	Бичиг хэргийн материал	1,915,664.0	1,971,064.0
35420	Аж ахуйн материал	8,539,288.0	9,829,988.0
35430	Сэлбэг хэрэгсэл	2,760,000.0	545,000.0
35440	Түлш, шатах тослох материал	6,508,600.0	2,631,800.0
35470	Бусад хангамжийн материал	40,837,650.0	48,380,439.0
35600	Мал амьтад	7,800,000.0	19,000,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,588,060,453.6	1,587,011,634.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,588,060,453.6	1,587,011,634.7
392	Биет хөрөнгө	1,353,484,953.6	1,352,623,634.7
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,248,770,143.0	1,289,032,413.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-289,389,366.2	-369,574,498.3
39203	Авто-тээврийн хэрэгсэл	222,743,956.0	222,743,956.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-119,809,929.1	-138,610,686.6
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	346,313,259.0	368,909,719.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-119,509,081.6	-149,618,726.8
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	120,794,509.3	199,051,103.3
39208	Хуримтлагдсан элэгдэл	-56,428,536.8	-69,309,645.0
393	Биет бус хөрөнгө	234,575,500.0	234,388,000.0
39301	Програм хангамж	1,647,500.0	1,647,500.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,460,000.0	-1,647,500.0
39303	Бусад биет бус хөрөнгө	234,388,000.0	234,388,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,656,513,722.0	1,675,406,713.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	3,051,782.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	3,051,782.9
413	Өглөг	0.0	3,051,782.9
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	3,051,782.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,656,513,722.0	1,672,354,930.5
51	Засгийн газрын хувь оролцоо	1,656,513,722.0	1,672,354,930.5
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	668,904,654.5	668,904,654.5
51101	Өмч: - төрийн	668,904,654.5	668,904,654.5
512	Хуримтлагдсан үр дүн	857,106,207.8	875,395,579.4
51210	Өмнөх үеийн үр дүн	857,106,207.8	859,554,370.9
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	15,841,208.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,502,859.7	128,054,696.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,656,513,722.0	1,675,406,713.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	739,672,579.0	719,164,552.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	270,531,816.0	157,982,889.0
120	Нийтлэг татварын бус орлого	270,531,816.0	157,982,889.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	270,531,816.0	157,982,889.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	270,531,816.0	157,982,889.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	469,140,763.0	561,181,663.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,395,813.0	36,846,571.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,395,813.0	36,846,571.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	448,744,950.0	524,335,092.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	448,744,950.0	524,335,092.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	464,769,071.3	698,812,822.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,769,071.3	697,054,822.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	429,169,894.8	675,642,810.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,161,275.7	347,518,241.1
210101	Үндсэн цалин	128,063,709.7	260,791,703.4
210102	Нэмэгдэл	25,097,566.0	74,167,237.8
210104	Урамшуулал	0.0	12,559,300.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,668,331.2	44,632,730.3
210201	Тэтгэврийн даатгал	13,657,477.5	30,550,470.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,407,290.1	3,584,974.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,228,384.6	2,781,946.3
210204	Ажилгүйдлийн даатгал	307,016.3	675,765.7
210205	Эрүүл мэндийн даатгал	3,068,162.7	7,039,573.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,371,717.0	54,117,733.4
210301	Гэрэл, цахилгаан	8,830,595.8	11,297,683.4
210302	Түлш, халаалт	23,442,521.2	42,280,250.0
210303	Цэвэр, бохир ус	98,600.0	539,800.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,122,600.0	36,339,699.8
210401	Бичиг хэрэг	1,422,900.0	1,912,600.0
210402	Тээвэр, шатахуун	19,552,700.0	14,448,599.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,037,400.0	1,900,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,109,600.0	1,696,000.0
210408	Бараа материал акталсны зардал	0.0	16,382,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,100,000.0	3,915,000.0
210604	Урсгал засвар	2,100,000.0	3,915,000.0
2107	Томилолт, зочны зардал	4,535,900.0	7,279,400.0
210702	Дотоод албан томилолт	4,535,900.0	7,279,400.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,080,862.5	6,508,898.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,472,399.5	5,045,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	461,525.0	470,750.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	517,938.0	204,228.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	197,000.0	356,920.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,129,208.3	175,331,107.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,448,200.0	9,798,110.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	127,681,008.3	165,532,997.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,599,176.6	21,412,012.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,739,300.0	12,011,900.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,184,300.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	11,011,900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	555,000.0	1,000,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,859,876.6	9,400,112.1
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,859,876.6	9,400,112.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,000,000.0	1,758,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	12,000,000.0	1,758,000.0
222001	Тоног төхөөрөмж	0.0	1,758,000.0
223001	Бусад хөрөнгө	12,000,000.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	274,903,507.7	20,351,729.5
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	4,510,521.1
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.0	4,510,521.1
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.0	-4,510,521.1
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	274,903,507.7	15,841,208.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	469,140,763.0	561,181,663.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	469,140,763.0	561,181,663.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,395,813.0	36,846,571.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,395,813.0	36,846,571.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	448,744,950.0	524,335,092.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	448,744,950.0	524,335,092.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	333,781,663.0	512,080,063.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	333,781,663.0	512,080,063.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	309,239,086.5	490,668,050.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,161,275.7	349,963,394.8
210101	Үндсэн цалин	128,063,709.7	257,203,534.2
210102	Нэмэгдэл	25,097,566.0	80,527,397.0
210104	Урамшуулал	0.0	12,232,463.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,668,331.2	41,580,515.0
210201	Тэтгэврийн даатгал	13,657,477.5	28,311,869.1
210202	Тэтгэмжийн даатгал	1,407,290.1	3,333,262.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,228,384.6	2,710,058.7
210204	Ажилгүйдлийн даатгал	307,016.3	681,958.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,068,162.7	6,543,367.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,499,917.0	50,382,133.4
210301	Гэрэл, цахилгаан	8,830,595.8	11,297,683.4
210302	Түлш, халаалт	24,936,121.2	38,384,450.0
210303	Цэвэр, бохир ус	733,200.0	700,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,708,532.0	17,355,599.8
210401	Бичиг хэрэг	1,350,000.0	1,991,000.0
210402	Тээвэр, шатахуун	8,762,450.0	9,560,599.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,401,100.0	2,604,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,194,982.0	3,200,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,300,000.0	4,300,000.0
210604	Урсгал засвар	3,300,000.0	4,300,000.0
2107	Томилолт, зочны зардал	4,535,900.0	7,279,400.0
210702	Дотоод албан томилолт	4,535,900.0	7,279,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,080,862.5	10,008,898.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,472,399.5	8,545,000.0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	565,463.0	470,750.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,000.0	204,228.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	384,000.0	356,920.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,284,268.0	9,798,110.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,284,268.0	9,798,110.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,542,576.6	21,412,012.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,682,700.0	12,011,900.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,184,300.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	11,011,900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,498,400.0	1,000,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,859,876.6	9,400,112.1
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,859,876.6	9,400,112.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	135,359,100.0	49,101,600.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	135,359,100.0	49,101,600.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	135,359,100.0	49,101,600.0
2200	Дотоод эх үүсвэрээр	135,359,100.0	49,101,600.0
222001	Тоног төхөөрөмж	3,492,000.0	19,673,600.0
223001	Бусад хөрөнгө	12,000,000.0	0.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	119,867,100.0	29,428,000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-135,359,100.0	-49,101,600.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	112,792,434.0	912,199,948.2
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	61,505.9	61,505.9
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	112,853,939.9	912,261,454.1
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	469,410,266.1	469,410,266.1
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	857,106,207.8	1,656,513,722.0
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	857,106,207.8	1,656,513,722.0
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,448,163.1	2,448,163.1
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	859,554,370.9	1,658,961,885.1
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(2,448,163.1)	-	(2,448,163.1)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	15,841,208.4	15,841,208.4
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	668,904,654.5	128,054,696.6	875,395,579.4	1,672,354,930.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	495,956,400.0	468,730,381.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	495,956,400.0	468,730,381.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,944,500.0	456,118,481.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,244,600.0	326,028,612.0
210101	Үндсэн цалин	291,074,000.0	260,741,791.0
210102	Нэмэгдэл	48,170,600.0	60,581,921.0
210104	Урамшуулал	0.0	4,704,900.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,405,600.0	40,358,838.0
210201	Тэтгэврийн даатгал	28,835,800.0	27,579,424.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,392,400.0	3,200,032.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,714,000.0	2,600,722.7
210204	Ажилгүйдлийн даатгал	678,500.0	625,377.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,784,900.0	6,353,282.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,205,020.0	50,382,133.4
210301	Гэрэл, цахилгаан	15,157,520.0	11,297,683.4
210302	Түлш, халаалт	41,347,500.0	38,384,450.0
210303	Цэвэр, бохир ус	700,000.0	700,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,364,680.0	17,805,599.8
210401	Бичиг хэрэг	2,000,080.0	1,991,000.0
210402	Тээвэр, шатахуун	9,560,600.0	9,610,599.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,604,000.0	2,604,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.0	3,600,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,300,000.0	4,300,000.0
210604	Урсгал засвар	4,300,000.0	4,300,000.0
2107	Томилолт, зочны зардал	7,279,600.0	7,279,400.0
210702	Дотоод албан томилолт	7,279,600.0	7,279,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,145,000.0	9,963,898.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,500,000.0	8,500,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,018,000.0	470,750.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,000.0	204,228.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.0	356,920.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,011,900.0	12,611,900.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,011,900.0	12,611,900.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,011,900.0	11,011,900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	1,600,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,000,000.0	49,101,600.0
2200	Дотоод эх үүсвэрээр	50,000,000.0	49,101,600.0
222001	Тоног төхөөрөмж	50,000,000.0	49,101,600.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	550,956,200.0	524,335,092.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	547,756,200.0	524,335,092.0
132001	Орон нутгийн төсвөөс	547,756,200.0	524,335,092.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,200,000.0	0.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,200,000.0	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022 он	2023 он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,253,160.00	36,365,106.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,253,160.00	36,365,106.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,053,160.00	36,365,106.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	23,934,782.78
210102	Нэмэгдэл	0.00	23,934,782.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	1,221,677.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	732,445.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	133,230.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	109,336.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	56,581.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	190,085.00
2104	Хангамж, бараа материалын зардал	107,250.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	107,250.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	213,750.00	4,364,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	213,750.00	4,364,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,732,160.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,732,160.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	0.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	6,844,646.22
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,326,750.00	36,365,106.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,326,750.00	36,365,106.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,326,750.00	36,190,106.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	0.00	175,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий Аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

2023 оныг “Сум орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чангатган манлайлан ажиллах” зорилго дэвшүүлэн 8 зорилт, 31 ажил, арга хэмжээг төлөвлөн ажилласан. Дэвшүүлсэн зорилго, зорилт, арга хэмжээг 93,9 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйл “Нэгжийн эдийн засгийн үндсийг бүрдүүлэх төр орон нутгийн удирдлага”, 20 дугаар зүйл “Орон нутгийн чиг үүрэг”, 35 дугаар зүйл “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх”, мөн Төсвийн тухай хуулийн зарим зүйл заалт тухайлбал 8 дугаар зүйл “Төсвийн цагалбар”, 23 дугаар зүйл “Төсвийн орлого”, 24 дүгээр зүйл “Төсвийн зарлага”, 27 дугаар зүйл “Төсвийн төсөлд тавигдах шаардлага”-д өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус байгууллагын дотоод хяналтыг төрийн сангийн мэргэжилтэн нь хариуцан гүйцэтгэдэг бөгөөд хараат байдалтайгаар ажиллаж байна.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Аймгийн засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын алба хариуцан гүйцэтгэж байна. 2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд Санхүү хяналт, аудитын албанаас аудит хийгээгүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Санхүү төрийн сангийн хэлтсийн 2012 оны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,893.0 мянган төгрөгөөр буюу 1,1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	5,944.7	5,944.7
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	68,453.3	82,450.4	13,997.1
Үндсэн хөрөнгө	1,588,060.5	1,587,011.6	(1,048.8)
Нийт хөрөнгө	1,656,513.7	1,675,406.7	18,893.0
Өр төлбөр	-	3,051.8	3,051.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,656,513.7	1,672,354.9	15,841.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,656,513.7	1,675,406.7	18,893.0

Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал 55.4 мянган төгрөг, аж ахуйн материал 1,290.7 мянган төгрөг, бусад хангамжийн материал 7,542.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, сэлбэг хэрэгсэл 2,215.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 3,876.8 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Малын үүлдэр угсааг сайжруулах, цөм сүрэг бий болгоход зориулан 19,000.0 мянган төгрөгийн шилмэл үүлдрийн хуц шилжүүлэн өгсөн нь бараа материалын үлдэгдэл 13,997.1 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 12,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 13,674.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 19,025.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 34,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 27,763.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 62,533.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө данс 2023 онд 1,048.8 мянган төгрөгөөр буурахад 27,879.0

мянган төгрөгийн хөрөнгө акталсан, 165,532.9 мянган төгрөгийн элэгдэл нэмж байгуулсан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 333,281.0 мянган төгрөг, нийт зарлагыг 333,281.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 18,000.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 230.67 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 545,956.1 мянган төгрөгийг санхүүжихээр баталсан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 524,335.1 мянган төгрөг буюу 96,0 хувь санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 514,934.9 мянган төгрөг буюу 98,2 хувьтай байгаа нь цалин хөлс болон урамшил 9,400.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Үндсэн үйл ажиллагааны зардал	336,315.10	328,163.49	8,151.61	97.6
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	88,940.70	76,321.40	12,619.30	85.8
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны үйл ажиллагааны зардал	50,488.40	45,536.70	4,951.70	90.2
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	12,011.90	12,011.90	-	100.0
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад	50,000.00	49,101.60	898.40	98.2
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.00	5,000.00	-	100.0
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	3,200.00	3,200.00	-	100.0
	Дүн	545,956.10	519,335.09	26,621.01	95.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансанд 36,365.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн нэмэгдэл цалинд 23,934.8 мянган төгрөг, ЭМНДШ-д 1,221.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,364.0 мянган төгрөг зарцуулж 6,844.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	оныг “Сум орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чангатган манлайлан ажиллах” зорилго дэвшүүлэн 8 зорилт, 31 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжилт 97.5	336,315.10	328,163.49
2	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80103 /Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай гэрээт ажилчдын цалин хөлс болон нэмэгдэл	Хэрэгжилт 85.8	88,940.70	76,321.40
3	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80106 /Баг, хорооны үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	Сумын багийн иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Хэрэгжилт 90.1	50,488.40	45,536.70
4	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2023.01.01 2023.12.31	Тэтгвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, хөдөлмөрийн дотоод журамд бусад нөхцөл	Хэрэгжилт 100	12,011.90	12,011.90
5	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80918 /Бусад	2023.01.01 2023.12.31	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж	Хэрэгжилт 98.2	50,000.00	49,101.60
6	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-81102 /Орон нутгийн нөөц хөрөнгө	2023.01.01 2023.12.31	Сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх	Хэрэгжилт 100	5,000.00	5,000.00
7	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-82212 /Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Байгаль орчны нөлөөллийг бууруулах, чадварийг нэмэгдүүлэх	Хэрэгжилт 100	3,200.00	3,200.00
	Дүн				545,956.10	519,335.09

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1 хөтөлбөр, арга хэмжээг 93,7 хувьтай хийж гүйцэтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2023 онд төсвийн хөрөнгөөр Морьт ойл ХХК-иас шатахуун 14,587.5 мянган төгрөг, Бүтээмж-Оюу ХХК-иас нүүрс 35,017.6 мянган төгрөг, Гранада ААК-иас 14,435.0 мянган төгрөгөөр тавилга, Мөнх тод хүлэг ХХК-иас 4,590.0 мянган төгрөгөөр тавилга, цахим дэлгүүрээс 7,090.0 мянган төгрөгөөр компьютер, Пи Си Молл ХХК-иас 3,299.9 мянган төгрөгөөр компьютер худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төрийн хэмнэлтийн тухай хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №01/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн орлого 739,672.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,095.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,311.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага ажлын төлөвлөгөө гарж ажиллаагүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй байна. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгах явцад тус байгууллагын бүртгэлд байгаа авто тээврийн хэрэгслийн дугаарыг ялгагдах өнгө бүхий дугаараар солиулаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагад бүртгэлтэй машины улсын дугаарыг ялгагдах өнгө бүхий дугаараар солих

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ТТөв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 5.0 саяас дээших орлогын 19 гүйлгээ, зарлагын 7 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 5 гүйлгээг хугацаандаа байршуулсан байна. Төсвийн гүйцэтгэлийн 6, 7, 11 сарын мэдээг хугацаа хоцроосон, хөрөнгө зарцуулахтай холбоотой 2,000.0 мянган төгрөгийн 3 тушаалыг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл “Шилэн дансны зарчим” болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн зарцуулалттай холбоотой тушаал шийдвэрийг цаг хугацаанд нь ил, тод, үнэн зөвөөр шилэн дансанд байршуулж мэдээлж байх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 153,251.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 153,251.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн №18 дугаарын албан бичгээр ирүүлсэн байна. 2023 оноос эхлэн төрийн сангийн программ нь гүйлгээг нэхэмжлэх эхэлж үүссэний дараа хийдэг болсон нь дээрх зөрчлийг багасгах үндэс болсон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	62,882.9	2	62,882.9	100
Зөвлөмж	1	153,251.5	1	153,251.5	100
Нийт дүн	3	216,134.4	3	216,134.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалингийн зардлын гүйцэтгэл, авлага дансны үлдэгдэл, бараа материалын бүртгэл, түүнд тавих хяналтын талаар авч үзэхээр шийдвэрлэсэн.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 92,333.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 92,333.1 мянган төгрөгийн алдааг НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтыг үндэслэн залрууллаа.

Залруулсан алдаа:

- Цалингийн урьдчилгаа 10,100.0 мянган төгрөгийг суутгаж хаахдаа цалингийн урьдчилгаа дансанд давхар бүртгэсэн, 7,279.4 мянган төгрөгийн томилолтын хуудсыг хааж, шийдвэр гаргасан тухай бүрд бүртгээгүй, олгосон үед бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Түлш, шатах тослох материалын үлдэгдэл, зарцуулалтыг санхүүгийн программ, Е тайланд 1,743.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 15,090.0 мянган төгрөгийн өртөгтэй шинээр нэмэгдсэн 14 үндсэн хөрөнгөнд 456.2 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 31,800.1 мянган төгрөгөөр, батлагдсан төсөв, гүйцэтгэлийг мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайлан, ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, төсвийн хэлбэлзэл, журналуудад 40,953.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 283,498.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 8,008.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 8,000.0 мянган төгрөгийн албан шаардлага, 267,490.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот захирамж, Архуст сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн Б/01 захирамжийн дагуу сумын төрийн улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдлийг төсөвтөө багтаан шийдвэрлэх гэсэн дагуу 4 албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэлд 8,088.8 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3 “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Зураг төсөвгүй ахуй үйлчилгээний засварын ажил 8,000.0 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага өгөх гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Харилцагч байгууллага, иргэнтэй хийсэн худалдан авалтыг төлбөрийн цахим баримт, нэхэмжлэхийн дүнтэй тулгалт хийхэд 5,836.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 347 дугаар тушаалын “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д “Төлбөрийн баримт” заалтыг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил үйлчилгээ бүрийг цахим баримтаар баталгаажуулах

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 261,654.0 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох”

тухай заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах боломжтой бол дахин үнэлэх, боломжгүй бол эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт

Үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн тоог газар эзэмших эрхийн бүртгэлтэй тулгахад зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын асуудал хариуцсан байгууллагад уламжлан байгууллагын эзэмшиж байгаа газрын эрх, кадастрыг гаргуулж бүртгэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн урьдчилгааг суутгаж хаахадаа цалингийн урьдчилгаа дансанд давхар бүртгэсэн байна.	1	10,100.0			1	10,100.0	1	10,100.00
Түлш шатах материалын үлдэгдэл, зарцуулалтын санхүүгийн программ, Е тайланд зөрүүтэй тайлагнасан байна.	1	1,743.5			1	1,743.5	1	1,743.51
Тайлант онд 15,090.0 мянган төгрөгийн өртөгтэй шинээр нэмэгдсэн 14 үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байна.	1	456.2			1	456.2	1	456.22
Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг зөрүүтэй тайлагнасан	1	31,800.1			1	31,800.1	1	31,800.10
Батлагдсан төсөв, гүйцэтгэлийг мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайлан, ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, төсвийн хэлбэлзэл, журналуудад зөрүүтэй тайлагнасан байна	1	40,953.8			1	40,953.8	1	40,953.85
Томилолтын хуудсыг хааж, шийдвэр гаргасан тухай бүрд бүртгэлд бүртгээгүй, олгосон үед бүртгэсэн	1	7,279.4					1	7,279.40
Дүн	6	92,333.1			6	92,333.08	6	92,333.08

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дунг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байна.	1	5,866.0					1	5,866.0		
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 261,654.0 мянган төгрөгийн өртгөтэй 87 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	261,654.0					1	261,654.0		
Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй байгаа газар эзэмших эрхийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа барилга, байгуулалмжтай тулгахад дутуу бүртгэсэн байна	1						1			
Зураг төсөвгүй ахуй үйлчилгээний засварын ажлыг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.	1	8000.0			1	8000.0	0	0	0	0
Улс төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгосон байна	1	8088.8	1	8088.8	0	0	0	0	0	0
Дүн	5	283,608.8	1	8,088.8	1	8,000.0	3	267,520.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил:									
Төсвийн хөрөнгө зарцуулахтай холбоотой 3 тушаалыг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.	1	2,000.0						1	2,000.0
Дүн	1	2,000.0	0	-	0	-	1	2,000.0	
Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал:									
Төсвийн байгууллагын бүртгэлд байгаа автотээврийн хэрэгслийн дугаарыг ялгагдах өнгө бүхий дугаараар солиулаагүй байна.	1							1	
Дүн	1	-	-	-	-	-	1	-	